213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,200.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,302.9
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	5,302.9
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	224,775.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	224,775.1
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,895.1
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,366.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	168,958.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,555.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	132.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сүхбаатар аймгийн Уулбаян сумын засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Амартайван танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн мал амьтадын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэх, тайлагналыг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 15 -аас 2022 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн 01/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Шударга, ил тод, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэн, мэргэшсэн чадварлаг баг хамт олноор иргэдэд үйлчилж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад оршино” гэж тодорхойлсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Уулбаян сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдахгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрэх магадлалтай байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Уулбаян сумын Засаг даргын 2021 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна. Уулбаян сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн

үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,442.3 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 68.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 48.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 224.7 сая, эцсийн үлдэгдэл 234.5 сая төгрөг болж, 9.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Арилжааны банк дахь харилцах	0.3	1.2	0.9	1
Төрийн сангийн харилцах	224.4	233.3	8.9	99
Дүн	224.7	234.5	9.8	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 234.5 сая төгрөгийн 233.3 сая төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 1.2 сая арилжааны банк дахь дансанд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах дансанд сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого 11.5, ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт 115.3, төсөвт байгууллагуудын жилийн эцсийн харилцахын үлдэгдлийг нэгдсэн дансанд төвлөрүүлсэн 77.2, байгууллагын банканд дахь дансны үлдэгдэл 1.8, төлөвлөгөөнөөс давсан татварын болон татварын бус орлого 28.7 сая төгрөг тус тус үлдэгдлээр үлджээ.

Аудитын илрүүлэлт:

- Цэвэр бохир ус, албан томилолт, бичиг хэргийн зардлаас 5.1 сая төгрөгийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй. /ЗДТГ-3.7 сая/, /Хүүхдийн цэцэрлэг - 1.4 сая/
- Сургалтын төлбөрийг төсвөөс төлж, төсвийг зориулалт бус зарцуулсан. /ИТХ-0.1 сая/
- "Төлбөрийн цахим систем"-д нийт 57.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээний төлбөр ebarimt-аар шивээгдээгүй. /ОНХС/
- Иргэдийн саналаар дэмжигдээгүй "Өвөлжилтийн бэлтгэл хангах", "ЕБС-ийн байрны-зураг төсөв" төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлсэн байна. /ОНХС-46 сая/
- Нийт 9 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 5.6 сая төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгээгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна./ЕБС-5.6 сая/

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 171.9 сая, эцсийн үлдэгдэл 247.9 сая төгрөг болж, 76.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	0.5	0.5
Бусад авлага	19.1	55.8	36.7
Зээлийн авлага	152.8	191.6	38.8
Дүн	171.9	247.9	76.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 27.3 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн үндсэн зээл, зээлийн хүүгийн төлбөр 27.3 сая төгрөгийн авлага байна.

Бусад авлагад Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 45.2 сая, төрөөс олгогдох усны төлбөрийг буцаан олгох 5.3 сая, уурын зуухны урьдчилгаа 4.3 сая, томилолтын урьдчилгаа 0.5 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

-Томилолтын зардлаас урьдчилгаа 0.5 сая төгрөг олгож, суутган тооцоогүй авлагаар илэрхийлсэн. /ЗДТГ-0.5 сая/

- Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагатай байна. /ЭМТ-45.2 сая/

- Сум хөгжүүлэх сангаас авсан иргэд зээлийн үндсэн төлөлт, хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, барагдуулаагүй./3.6 сая/

- Сум хөгжүүлэх сангаас авсан иргэдийн хүүгийн төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй./ СХС-0.2 сая/

- Авлагын дансны үлдэгдэлд 0.5 сая төгрөгийн он дамжсан авлагатай байна./ЕБС-0.5 сая/

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 256.0 сая, эцсийн үлдэгдэл 308.5 сая төгрөг болж, 52.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	7.3	5.5	-1.8
Эм боох материал	12.0	16.0	4.0
Бичиг хэргийн материал	6.2	7.4	1.2
Аж ахуйн материал	132.2	153.3	21.1
Сэлбэг хэрэгсэл	2.8	7.0	4.2
Түлш тослох материал	2.0	3.3	1.3
Хүнсний материал	5.0	3.2	-1.8
Бусад хангамжийн материал	12.0	35.8	23.8
Мал амьтад	76.5	77.0	0.5
Дүн	256.0	308.5	52.5

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 308.5 сая төгрөгийн үлдэгдэлд аж ахуй, эм боох, тусгай зориулалтын материал болон мал амьтдын үлдэгдэл гол нөлөөлж байна. Мөн бараа

материалын үлдэгдлийн 44.9 хувийг ЗДТГ, 19.8 хувийг Ерөнхий боловсролын сургууль, 18.1 хувийг Хүүхдийн цэцэрлэг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалын тайланд 2.8 сая төгрөгийн эмийг нэг бүрийн үнэ, тоо хэмжээ, өртгөөр орлого авч тайлагнаагүй. /ЭМТ-2.8 сая/
- Хоол хүнсний материалыг нөөцөлж, төсөвт төвлөрүүлээгүй. /ЕБС-2.1 сая/

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,582.6 сая, эцсийн үлдэгдэл 4,582.6 сая төгрөг болж, 579.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	3,008.0	3,328.3	320.3
Тээврийн хэрэгсэл	220.7	187.3	-33.4
Машин тоног төхөөрөмж	469.7	584.5	114.8
Тавилга эд хогшил	168.7	206.9	38.2
Номын фонд	14.6	18.6	4.0
Бусад үндсэн хөрөнгө	655.1	790.9	135.8
Программ хангамж	1.6	1.6	-
Бусад биет бус хөрөнгө	44.2	44.2	-
Дүн	4,582.6	5,162.3	579.7

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 22.6 сая, үнэ төлбөргүй хандиваар 590.4 сая нийт 613.0 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, АИТХ-ын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 37 тоот тогтоолоор сумын ЗДТГ-ын 20.0 сая төгрөгийн 1 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаа хийж, 13.3 сая төгрөгийн 1 тээврийн хэрэгслийг акталсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж, баталгаажуулаагүй. /ЭМТ/
- Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, хөрөнгө бүртгэлтэй байна. /ЕБС-3312 ш/, /ЗДТГ-74 ш/, /ЭМТ-86 ш/, /Хүүхдийн цэцэрлэг-78ш/

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 48.6 сая, эцсийн үлдэгдэл 12.6 сая төгрөг болж, 30.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>				
Ажилчидтай холбогдсон өглөг		2.0	2.0	0
Байгууллагад төлөх	48.6	10.6	-38.0	100
Татварын өглөг				
Хувь хүнд төлөх өглөг				
Нийт дүн	48.6	12.6	36.0	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст байгууллагад төлөх 12.6 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Энэ нь ЗГ-аас олгосон усны 5.3 сая төгрөгийн хөнгөлөлт тайлант оны эцэст орж ирснээс шалтгаалжээ.

3.5.6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,581.6 сая төгрөг болж 534.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал				
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,355.5	1,355.5	-	0
Хуримтлагдсан үр дүн	1,280.2	1,814.4	534.2	100
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,411.7	1,411.7	-	0
Дүн	4,047.4	4,581.6	534.2	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 4,187.0 сая төгрөг болж, өмнөх оноос 632.0 сая төгрөг буюу 18 хувиар өссөн байна. Орлого нэмэгдэхэд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 267.7 сая, татварын ба татварын бус орлого 91.5 сая, орон нутгийн төсвийн санхүүжилт 92.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг 1,389.8, аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 562.0, ОНХС-аас 185.3, орон нутгийн төсвөөс санхүүжих 876.8, ЭМД-аас 58.3, орон нутгийн төсвийн орлогоор 203.4, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 53.5, нэмэлт санхүүжилтийн орлого 224.8, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 633.1 сая нийт 4,187.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Ковид-19 цар тахлын үед ард иргэдээс бэлнээр өгсөн хандив тусламжийг төсвийн харилцах дансанд төвлөрүүлээгүй. /ЭМТ-3.6 сая/
- Сум хөгжүүлэх сангаас авсан иргэд зээлийн гэрээ хугацаа дуусч, зээлийн үндсэн төлөлт, хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, барагдуулаагүй. /СХС-27.3 сая/

3.5.8 Зардлын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зарлага 3,442.3 сая төгрөг болж өмнөх оноос 160.4 сая төгрөг буюу 4.9 хувиар өссөн байна. Зардал өсөхөд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 118.6, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 15.7, урсгал шилжүүлэг 125.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд цалин хөлс нэмэгдэл урамшлын зардалд 1,448.7, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 189.1, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 119.4, хангамж, бараа материалын зардал 52.0, норматив зардалд 109.1, эд хогшил, урсгал засварын зардалд 17.8, томилот зочны зардалд 8.1, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 59.6, бараа үйлчилгээний бусад зардалд 452.7, урсгал шилжүүлэгт 985.8 сая нийт 3,442.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Түлш халаалт, цэвэр бохир ус, урсгал засвар, дотоод албан томилолт, аудит баталгаажуулах, зэрэглэл тогтоох, бараа үйлчилгээний бусад зардлаас материал, ажил үйлчилгээ худалдан авч хоорондын тооцооны дансаар бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан. /ЗДТГ- 43.4/
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор Ковид-19 цар тахлын нөхцөлд төсвийг үр ашигтай зарцуулж, хэмнэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг баримтлалгүй төсвийг зарцуулсан. /ЗДТГ-6.4/
- Ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг төсвөөс илүү шилжүүлж, зардлаар илэрхийлсэн. /ЭМТ-0.6 сая/
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд ажилчны цалинг илүү тайлагнасан. /ЭМТ-1.5 сая/
- Давхар ажил эрхэлдэг 1 ажилтны цалингаас ХХОАТ-ыг тооцоогүйгээс 0.3 сая төгрөгийг дутуу суутгасан. /ЕБС-0.3 сая/
- Нийт 11 ажилтны цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт тооцоогүйгээс 0.3 сая төгрөгийг цалингаас илүү тооцсон. /ЕБС-0.3 сая/

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Уулбаян сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор татварын орлого 93.3 сая төгрөг, татварын бус орлого 85.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 203.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 25.2 сая төгрөгөөр давсан байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өссөн + Буурсан -
НИЙТ ОРЛОГО	178.3	203.5	25.2
1. ТАТВАРЫН ОРЛОГО	93.3	155.6	62.3
Хүн амын орлогын албан татвар	41.2	51.9	10.7
Үйл ажиллагааны орлого	1.2	2.0	0.8
Хөрөнгийн орлого	15.0	20.3	5.3
Шууд бус орлого	25.0	26.0	1.0
Бусад татвар		3.6	3.6
Өмчийн татвар	41.1	65.4	24.3
Бууны албан татвар	1.1	0.8	-0.3
Малын тоо толгойн албан татвар	40.0	64.6	24.6
Бусад татвар (төлбөр, хураамж)	11.0	38.0	27.0
Улсын тэмдэгтийн хураамж	2.0	2.6	0.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3.0	0.1	-2.9
Газрын төлбөр	6.0	7.3	1.3
Ан агнуурын нөөц ашигласны төлбөр		27.7	27.7
Ус ашигласны төлбөр		0.3	0.3
2. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85.0	48.1	-36.9
Хүү, торгуулийн орлого	15.0	7.7	-7.3
Бусад орлого	70.0	40.4	-29.6

Орон нутгийн татварын орлого 62.3 сая төгрөгөөр давж, татварын бус орлого 36.9 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Малын тоо толгойн татвар 24.6 сая, төлөвлөгдөөгүй

ан агнуур нөөц ашигласны төлбөрийн орлого 27.7 сая төгрөг төвлөрч, татварын орлого давсан байна. Харин сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Эм Эль Цахиурт овоо ХХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу хандив, тусламжийн орлого 30.0 сая төгрөг төвлөрөөгүй нь татварын бус орлого тасрахад нөлөөлжээ.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 онд татварын орлогыг 53.3 сая, татварын бус орлогыг 85.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг тодотгон 40.0 сая төгрөгөөр татварын орлогыг нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь малын тоо толгойн албан татварыг баталсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 2,629.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд 2,230.0 сая, хөрөнгийн зардалд 300.8 сая, сум хөгжүүлэх сангийн зээлд 99.0 сая төгрөг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,389.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 884.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 185.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 30.7 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 139.6 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,370.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэг, 185.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 804.6 сая төгрөгийг орон нутгийн төсөв, 13.1 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сан, 56.8 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого бүрдэж, нийтдээ 2,430.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 79.8 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 17.6 сая, улсын төсвөөс 19.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгожээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,390.1 сая төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдлийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэн, санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 5.9, ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 27.4, дээд шатны төсвийн захирагчаас 71.2, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 120.3 сая, нийт 224.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлсөнд 37.9, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4.6, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 14.6, хангамж бараа материалын зардалд 2.8, нормативд зардалд 44.8, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 8.7, бараа үйлчилгээний бусад зардалд 80.8, урсгал шилжүүлэг 25.2 нийт 219.3 сая төгрөгийг зарцуулж, 5.3 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 148 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27 зарлагын гүйлгээний 859.3 сая, урсгал санхүүжилтийн 120 гүйлгээний 642.5 сая төгрөгийг гүйлгээг мэдээлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст мэдээллийг ил тод байршуулахаас мэдээллийг ил тод байршуулаагүй, мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. /ЕБС, ЗДТГ, ИТХ, ЭМТ, Хүүхдийн цэцэрлэг/

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	-	-	100
Нийт	2	-	2	-	-	-	100

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 орон нутгийн тусгайн сан, эмийн эргэлтийн сан 1 нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, “Хязгаарлалттай” 1 /Эрүүл мэндийн төв/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 107.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 102.1 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 5.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 5.3 сая төгрөгөөр авлагыг дутуу, 5.3 сая төгрөгөөр өр төлбөрийг дутуу нэгтгэсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 91.5 сая төгрөгөөр санхүүжилтийн орлого нэгтгэсэн;

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 148 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27 зарлагын гүйлгээний 859.3 сая, урсгал санхүүжилтийн 120 гүйлгээний 642.5 сая төгрөгийг гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалт болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын иж бүрэн байх, толилуулга, тасалбар болголт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага

Төвлөрүүлэн захирагчид 5.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,036.1 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 34.7 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 170.2 сая төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 831.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 12 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх дараах анхаарал татахуйц асуудал байна.

Тухайлбал:

- Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар биологийн хөрөнгө болох мал амьтадыг бодит үнэ цэнийн аргаар санхүүгийн тайланд толилуулах,
- ОНХС-аар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг ЗДТГ-т бүртгэх бус тус санд нь захиалагчийн зүгээс бүртгэж байгаа байдлыг хамруулан авч үзэхээр төлөвлөж байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал:

4.1.1 Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэнийн аргаар толилуулаагүй нийтлэг алдаа гарсан байна.

4.1.2 Эрсдэл: НББ-ийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.2.1 Илрүүлэлт:

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

4.2.2 Эрсдэл

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

4.2.3 Өгсөн зөвлөмж

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.3.1 Илрүүлэлт: Нэгтгэгдсэн байгууллага хооронд болон төсвийн төвлөрүүлэн захирагч хооронд үүссэн 5.3 сая төгрөгийн өглөгийн давхардсан ажил гүйлгээний устгах бичилтийг дутуу тайлагнасан.

4.3.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх

4.3.3 Өгсөн зөвлөмж Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 388 дугаар тушаалыг дагаж мөрдөн ажиллах

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:
2021

Аудитын
нэр:

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын
Засаг дарга

Аудитын код: СБА-
2022/11/НА-СТА-ТТЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг
дарга

Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 148 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.		Албан шаардлага	Засаг дарга Санхүү албаны дарга	Д.Амартайван Г.Оюунсайхан
2	Байгууллагын мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.	-	Зөвлөмж	Засаг дарга Санхүү албаны дарга	Г.Эрдэнэчулуун Х.Шинэцэцэг
3	Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна	-	Зөвлөмж	Засаг дарга Санхүү албаны дарга	Г.Эрдэнэчулуун Х.Шинэцэцэг
4	Нэгтгэгдсэн байгууллага хооронд болон төсвийн төвлөрүүлэн захирагч хооронд үүссэн 5.3 сая төгрөгийн өглөгийн давхардсан ажил гүйлгээний устгах бичилтийг дутуу тайлагнасан	5.3	Зөвлөмж	Засаг дарга Санхүү албаны дарга	Д.Амартайван Г.Оюунсайхан
	Дүн	5.3			